



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2020 оны 10 дугаар сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 10 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 10%-иар буюу 1,170 сая ам.доллараар буурч 10,423 сая ам.доллар байв. Үүнд экспорт 8%-иар буюу 543 сая ам.доллараар, импорт 12%-иар буюу 628 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 85 сая ам.доллараар өсч 1,549 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 10 сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2018/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,538	12,887	13,747	2,349	22%	861	7%	10,820	11,593	10,423	773	7%	(1,170)	-10%
Экспорт	6,201	7,012	7,620	811	13%	608	9%	5,945	6,529	5,986	584	10%	(543)	-8%
Импорт	4,337	5,875	6,128	1,537	35%	253	4%	4,876	5,065	4,437	189	4%	(628)	-12%
Тэнцэл	1,863	1,137	1,492	(726)		355	31%	1,069	1,464	1,549	395	37%	85	6%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2020 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 196 сая ам.доллараар өсч, 1,744 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 58% буюу 6,036 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 11% буюу 1,189 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 18%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 20%-иар буурлаа.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2020 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 15%-иар, өмнөх сараас 9%-иар тус тус өсч 2.014-д хүрлээ. Худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс өсөхөд зэсийн баяжмал болон алтны экспортын үнэ өссөнөөр тайлбарлагдаж байна. Харин өмнөх сараас өсөхөд зэс болон чулуун нүүрсний экспортын үнийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт 2020 оны эхний 10 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 8%-иар буюу 543 сая ам.доллараар буурав. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортыг 4 нэгж хувиар бууруулах чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 2 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²	
1. Уул уурхай		5,267	89%		5,810	89%		5,548	93%		543	10%	9%	(262)	-5%	-4%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,205	1,669	28%	1,174	1,541	24%	1,140	1,346	22%	(128)	-8%	-2%	(195)	-13%	-3%	
1.2. Чулуун нүүрс	30,941	2,439	4%	32,334	2,748	42%	23,865	1,773	30%	309	13%	5%	(974)	-35%	-15%	
1.3. Боловсруулаагүй нефть	4,968	327	5%	5,428	303	5%	2,928	105	2%	(24)	-7%	0%	(198)	-65%	-3%	
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	6,048	274	5%	6,899	459	7%	6,945	527	9%	185	67%	3%	68	15%	1%	
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	3,432	144	2%	7,464	344	5%	22,785	1,322	22%	200	138%	3%	978	284%	15%	
1.6. Цайрын хүдэр, баяжмал	103	167	3%	109	156	2%	116	142	2%	(12)	-7%	0%	(14)	-9%	0%	
1.7. Жонош, лейцит, нефелинт	422	141	2%	558	170	3%	550	129	2%	30	21%	1%	(42)	-24%	-1%	
1.8. Молибдений хүдэр, баяжмал	5	40	1%	5	42	1%	5	33	1%	1	4%	0%	(9)	-21%	0%	
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	6	0%	1	5	0%	0	1	0%	(1)	-19%	0%	(4)	-86%	0%	
1.10. Мөнгө /тонн/	0	1	0%	0	-	0%	195,693	111	2%	(1)	0%	0%	111	0%	2%	
1.11. Бусад	434	58	1%	128	42	1%	72	60	1%	(7)	-28%	0%	18	42%	0%	
2. Мал аж ахуй		420	7%		424	6%		259	4%		4	1%	0%	(164)	-39%	-3%
2.1. Амьд мал, малын мах	26	59	1%	21	45	1%	15	29	0%	(14)	-25%	0%	(16)	-35%	0%	
2.2. Арьс, шир	275	13	0%	219	12	0%	145	7	0%	(1)	-9%	0%	(6)	-46%	0%	
2.3. Малын өлөн гэдэс	0	7	0%	0	7	0%	1	7	0%	(0)	-3%	0%	0	6%	0%	
2.4. Ноолуур	8	313	5%	8	336	5%	8	205	3%	23	7%	0%	(131)	-39%	-2%	
2.5. Ноос, бусад үс, хялгас	13	25	0%	13	22	0%	8	11	0%	(2)	-9%	0%	(12)	-52%	0%	
2.6. Бусад	3	3	0%	3	2	0%	0	1	0%	(1)	-22%	0%	(1)	-49%	0%	
3. Газар тариалан		7	0%		38	0%		9	0%		1	17%	0%	(0)	-1%	0%
4. Аж үйлдвэрлэл		250	4%		330	4%		181	3%		35	14%	1%	(116)	-41%	-2%
4.1. Хүнс	20	57	1%	17	42	1%	17	46	1%	(15)	-26%	0%	4	9%	0%	
4.2. Ноолууран эдлэл	1	30	1%	1	37	1%	1	28	0%	7	23%	0%	(9)	-24%	0%	
4.3. Бусад хувацас, гутал, эдлэл	3	21	0%	3	16	0%	4	14	0%	(5)	-24%	0%	(2)	-15%	0%	
4.4. Уул уурхай	46	90	2%	41	93	1%	16	43	1%	2	3%	0%	(50)	-54%	-1%	
4.5. Цахилгаан, электрон бараа	0	3	0%	0	1	0%	0	1	0%	(2)	-69%	0%	(0)	-14%	0%	
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анг	3	45	1%	2	91	1%	2	34	1%	46	102%	1%	(57)	-63%	-1%	
4.7. Бусад	118	4	0%	167	6	0%	142	4	0%	2	40%	0%	(2)	-30%	0%	
5. Бусад		1	0%		1	0%		1	0%		(0)	-21%	0%	0	19%	0%
Нийт дүн		5,945			6,529			5,986			584	10%		(543)	-8%	

² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2020 оны эхний 10 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	216		(478)		(262)	-5%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(41)	2%	(154)	79%	(195)	-13%
1.2. Чулуун нүүрс	(629)	65%	(345)	35%	(974)	-35%
1.3. Боловсруулаагүй нефть	(90)	45%	(108)	55%	(198)	-65%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	19	27%	49	73%	68	15%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	889	9%	89	9%	978	284%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	8	-56%	(22)	156%	(14)	-9%
1.7. Жонош, лейцит, нефелинт	(2)	4%	(40)	96%	(42)	-24%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3	-30%	(11)	130%	(9)	-21%
1.11. Бусад	(45)	-257%	63	357%	18	42%
2. Мал аж ахуй	(28)	17%	(137)	83%	(164)	-39%
2.1. Амьд мал, малын мах	(12)	80%	(3)	20%	(16)	-35%
2.2. Арьс, шир	(3)	60%	(2)	40%	(6)	-46%
2.4. Ноолуур	5	-4%	(136)	104%	(131)	-39%
3. Газар тариалан	(2)	173%	2	-163%	(0)	-1%
4. Аж үйлдвэрлэл	(341)	294%	225	-194%	(116)	-41%
5. Бусад	(0)	-192%	0	3%	0	19%
Нийт дүн	(154)		(389)		(543)	-8%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2020 оны эхний 10 сарын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулж, нийт 543 сая ам.долларын бууралтыг харвал:

1/ Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 216 сая ам.доллараар өсч, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 478 сая ам.доллараар буурсан. Үүнд чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ болон үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 1,170 сая ам.доллараар буурч алтны экспорт тоо хэмжээний болон үнийн өсөлтөөс хамаарч 978 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

2/ Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хувьд биет хэмжээний бууралтаас шалтгаалж 28 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 137 сая ам.доллараар буурав.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 10 дугаар сард, 1,900 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 27%-иар өссөн бол өмнөх сараас 2%-иар буурав. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,714; 120 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 16%-иар, төмрийн хүдэр 35%-иар тус тус өссөн байна. Харин өмнөх сартай харьцуулбал, зэсийн хүдэр 0.5%-иар өсч, харин төмрийн хүдрийн үнэ 5%-иар буурав. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 10 дугаар сард 74 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 13%-иар буурсан бол өмнөх сараас 11%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Импорт 2020 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12%-иар буюу 628 сая ам.доллараар буурав. Импортын 12 хувийн бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 4 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 6 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 2 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)			
	Тоо/хам (мян нэгж)	Дүн	%	Тоо/хам (мян нэгж)	Дүн	%	Тоо/хам (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²	
Хэрэглээний бүтээгдэхүүн		1,340	27%		1,367	27%		1,264	28%		27	2%	1%	(103)	-8%	-2%
Түргэн эдэлгээтэй	805	705	14%	743	699	14%	793	719	16%	(6)	-1%	0%	20	3%	0%	
Хүнс	383	488	10%	352	489	10%	373	501	17%	1	0%	0%	12	2%	0%	
Эм, тариа	2	98	2%	3	89	2%	3	95	2%	(9)	-9%	0%	5	6%	0%	
Бусад түргэн эдэлгээтэй бараа	419	120	2%	388	121	2%	418	123	3%	1	7%	0%	2	2%	0%	
Удаан эдэлгээтэй	197	635	13%	268	668	13%	247	546	12%	33	5%	7%	(123)	-18%	-2%	
Гутал, хуцас, цунх	49	61	1%	55	57	1%	71	59	1%	(3)	-6%	0%	2	4%	0%	
Гэр ахуйн цах. хэрэгсэл ба төвицлэг	80	95	2%	144	89	2%	100	86	2%	(6)	-6%	0%	(2)	-3%	0%	
Авто машин, түүний салбэг хэрэгсэл	1	411	8%	1	452	9%	1	323	7%	41	10%	7%	(129)	-29%	-3%	
Бусад удаан эдэлгээтэй бараа	67	69	1%	68	70	1%	74	77	2%	2	3%	0%	7	9%	0%	
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,236	2,015	41%	1,087	2,185	43%	1,273	1,978	45%	171	8%	3%	(207)	-9%	-4%	
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	27	1,263	26%	23	1,439	28%	31	1,202	27%	176	14%	4%	(237)	-16%	-5%	
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	378	8%	2	502	10%	7	429	10%	24	33%	3%	(73)	-15%	-1%	
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	26	884	18%	21	937	19%	24	773	17%	53	6%	1%	(164)	-18%	-3%	
Барилгын материал	691	572	12%	868	572	11%	1,146	541	12%	1	0%	0%	(31)	-5%	-1%	
Хөрөнгө оруулалтын бусад бараа	37	180	4%	38	174	3%	114	235	5%	(6)	-3%	0%	61	35%	1%	
Аж үйлдвэрлэлийн орц	1,306	608	12%	1,502	562	11%	1,466	534	12%	(46)	-8%	-1%	(28)	-5%	-1%	
Хүнсний орц	273	75	2%	44	20	0%	150	41	1%	(55)	-73%	-1%	21	102%	0%	
Химийн бүтээгдэхүүн	167	101	2%	188	101	2%	166	92	2%	(0)	0%	0%	(9)	-9%	0%	
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	66	25	1%	66	24	0%	60	20	0%	(1)	-6%	0%	(3)	-14%	0%	
Цахилгаан эрчим хүч	1	118	2%	1	120	2%	110	116	3%	1	1%	0%	(4)	-3%	0%	
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	1	0%	1	1	0%	1	1	0%	0	16%	0%	0	29%	0%	
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	729	289	6%	787	297	6%	787	284	6%	8	3%	0%	(33)	-11%	-1%	
Нефтийн бүтээгдэхүүн	1,306	906	19%	1,502	945	19%	1,466	647	15%	39	4%	1%	(298)	-32%	-6%	
Дизель түлш	694	460	9%	891	549	11%	800	338	8%	89	19%	2%	(212)	-39%	-4%	
АИ-92, АИ-95	297	211	4%	376	227	4%	418	175	4%	16	8%	0%	(52)	-23%	-1%	
А-80 болон бусад	314	236	5%	235	169	3%	249	134	3%	(67)	-28%	-1%	(35)	-21%	-1%	
Бусад	14	6	0%	5	5	0%	199	13	0%	(1)	-16%	0%	9	179%	0%	
Нийт дүн		4,876		5,065			4,437			189	4%		(628)	-12%		

%² - Нийт өсөлтэд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2020 он эхний 10 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
		%		%		%
Хэрэглээний бүтээгдэхүүн	1	-1%	(103)	101%	(103)	-8%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	471	-227%	(678)	327%	(207)	-9%
Аж үйлдвэрлэлийн орц	129		(157)		(28)	-5%
Нефтийн бүтээгдэхүүн	(14)	5%	(285)	95%	(298)	-32%
Дизель түлш	(39)	18%	(173)	82%	(212)	-39%
АИ-92, АИ-95	18	-34%	(69)	134%	(52)	-23%
А-80 болон бусад	7	-21%	(42)	121%	(35)	-21%
Бусад	13		(4)		9	179%
Нийт дүн	600	-96%	(1,227)	196%	(628)	-12%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд баатдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2020 оны эхний 10 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт импорт 628 сая ам.доллараар буурсан. Үүнд:

- Машин, механик тоног төхөөрөмжийн буюу хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 207 сая ам.доллараар,
- Дизель түлшний хэрэглээтэй холбоотойгоор нефтийн бүтээгдэхүүний импорт 298 сая ам.доллараар,
- Хэрэглээний бүтээгдэхүүний импорт 103 сая ам.доллараар,
- Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 28 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 32%-иар, өмнөх сараас 1%-иар тус тус буурч, тонн тутамд 435 ам.долларт хүрэв.